

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХУУЛЬ, ЭРХ
ЗҮЙН ХЭЛТСИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН
АЖЛЫН ТАЙЛАН**

2017.12.12

Тус хэлтэс нь хууль зүйн салбарын бодлого, зорилтын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилт, иргэдийн оролцоог дэмжиж соён гэгээрүүлэх, хууль, эрх зүйн туслалцаа, үйлчилгээг байгууллага, албан тушаалтан, иргэд, олон нийтэд хүртээмжтэй хэлбэрээр хүргэн, эрх зүйн зөвлөгөө мэдээллээр хангахын зэрэгцээ хэлтэс, агентлагийн удирдлагууд, сум, багийн Засаг дарга, сумдын орон тооны бус “Эрх зүйн хөтөч” багийн ахлагч буюу сумдын Засаг даргын тамгын газрын дарга болон бусад холбогдох албан тушаалтан, мэргэжилтнүүдийг хууль тогтоомж хэрэгжүүлэх, сурталчлах ажилд арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлж, шаардлагатай мэдээллээр хангаж, тэднээс гаргасан санал хүсэлтийг тухай бүрд нь шийдвэрлэн хариуг нэг бүрчлэн өгч, цаашид хэрэгжүүлэх ажлыг хэлтсийн жил, улирлын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган 2017 онд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн сан бүрдүүлэлт, бүртгэн цэгцлэх ажлын гүйцэтгэл, иргэд, аж ахуйн нэгжид цахим болон гарсангаас лавлагаа мэдээлэл өгсөн талаар

Тус онд эрх зүйн мэдээллийн өөрчлөлт хөдөлгөөний бүртгэлийн нэгдсэн санд нийт 364 эрх зүйн актыг бүртгэсэн ба үүнээс нэмэлт, өөрчлөлт орсон 247 хууль, Засгийн газрын тогтоол 16, УИХ-ын тогтоол 22, Үндсэн хуулийн цэцийн тогтоол 4, Ерөнхийлөгчийн зарлиг 9-ийг тус тус бүртгэн сангаа баяжуулж, өдөр тутмын болон хууль тогтоомжийг сурталчлан таниулах үйл ажиллагаандаа ашиглаж байна.


Хүчингүй болгосон болон нэмэлт өөрчлөлт орсон нийт 300 хууль, тогтоомжид тухай бүр эрх зүйн ангилал хийн, тамга тэмдэг дарж баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Цахим болон гарсангаас лавлагаа мэдээллийг 77 иргэнд өгч, уулзалтын бүртгэлийг хөтөлж ажиллалаа.

Аймгий Засаг даргын захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянажсанал дүгнэлт өгөх, тухайн жилд гаргасан захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг зохих журмын дагуу хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хянуулж, бүртгүүлсэн талаар

МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН БҮРТГЭЛ
2017 он

№	Аглын нэр	Нийт зүйл заалт	Насалт өөрчлөлт орсон акт	Хүчингүй болгосон зүйл заалт	Хурдасны тий	Нийлэгдсэн 36 сурвалж	Бүртгэсэн өмнө
1	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай (аномали-кадрүүтэй)	47	-	-	16		
2	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хүчингүй болгох тухай	2		Болохдоо	1		
3	Бяга, дүрэг, бөгөөд олон тусгай хуульд хяналт оруулах тухай	3	4.18, 5.18, 5.19, 5.21, 5.22, 5.23, 5.24, 5.25, 5.26, 5.27, 5.28, 5.29, 5.30, 5.31, 5.32, 5.33, 5.34, 5.35, 5.36, 5.37, 5.38, 5.39, 5.40, 5.41, 5.42, 5.43, 5.44, 5.45, 5.46, 5.47, 5.48, 5.49, 5.50, 5.51, 5.52, 5.53, 5.54, 5.55, 5.56, 5.57, 5.58, 5.59, 5.60, 5.61, 5.62, 5.63, 5.64, 5.65, 5.66, 5.67, 5.68, 5.69, 5.70, 5.71, 5.72, 5.73, 5.74, 5.75, 5.76, 5.77, 5.78, 5.79, 5.80, 5.81, 5.82, 5.83, 5.84, 5.85, 5.86, 5.87, 5.88, 5.89, 5.90, 5.91, 5.92, 5.93, 5.94, 5.95, 5.96, 5.97, 5.98, 5.99, 6.00	-	1		
4	Эмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд, насалт, өөрчлөлт оруулах тухай	3	11.4, 11.8, 16.38	-	1		
5	Дэлд бөгөөд олон тусгай хуульд хяналт оруулах тухай	2	5.23, 5.24, 5.25, 5.26, 5.27, 5.28, 5.29, 5.30, 5.31, 5.32, 5.33, 5.34, 5.35, 5.36, 5.37, 5.38, 5.39, 5.40, 5.41, 5.42, 5.43, 5.44, 5.45, 5.46, 5.47, 5.48, 5.49, 5.50, 5.51, 5.52, 5.53, 5.54, 5.55, 5.56, 5.57, 5.58, 5.59, 5.60, 5.61, 5.62, 5.63, 5.64, 5.65, 5.66, 5.67, 5.68, 5.69, 5.70, 5.71, 5.72, 5.73, 5.74, 5.75, 5.76, 5.77, 5.78, 5.79, 5.80, 5.81, 5.82, 5.83, 5.84, 5.85, 5.86, 5.87, 5.88, 5.89, 5.90, 5.91, 5.92, 5.93, 5.94, 5.95, 5.96, 5.97, 5.98, 5.99, 6.00	-	1		
6	Нөхцөлнө болгохын тухай хуульд хяналт, өөрчлөлт оруулах тухай	4	18.1, 18.2, 18.3, 18.4, 18.5, 18.6, 18.7, 18.8, 18.9, 18.10, 18.11, 18.12, 18.13, 18.14, 18.15, 18.16, 18.17, 18.18, 18.19, 18.20, 18.21, 18.22, 18.23, 18.24, 18.25, 18.26, 18.27, 18.28, 18.29, 18.30, 18.31, 18.32, 18.33, 18.34, 18.35, 18.36, 18.37, 18.38, 18.39, 18.40, 18.41, 18.42, 18.43, 18.44, 18.45, 18.46, 18.47, 18.48, 18.49, 18.50, 18.51, 18.52, 18.53, 18.54, 18.55, 18.56, 18.57, 18.58, 18.59, 18.60, 18.61, 18.62, 18.63, 18.64, 18.65, 18.66, 18.67, 18.68, 18.69, 18.70, 18.71, 18.72, 18.73, 18.74, 18.75, 18.76, 18.77, 18.78, 18.79, 18.80, 18.81, 18.82, 18.83, 18.84, 18.85, 18.86, 18.87, 18.88, 18.89, 18.90, 18.91, 18.92, 18.93, 18.94, 18.95, 18.96, 18.97, 18.98, 18.99, 19.00	-	1	2017.02.01 1805.9623	2017.02.14

“Аймгийн Засаг даргын хянах, баталгаажуулах, сумдын даргын эрхлэх хүрээний хэлтэс, нарын баталсан эрх зүйн актыг Захиргааны ерөнхий хуульд А/91 дүгээр захирамжаар журмын дагуу аймгийн Засаг



захирамжийн төслийг Засаг дарга, Засаг агентлагийн дарга хянах журам”-ыг нийцүүлэн 2017 оны шинэчилэн баталж, даргаас тус онд нийт

321 захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянаж, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжөөр хангаж, төслийн шатанд захирамж боловсруулсан этгээдээр санал авах хуудас болон хяналтын дагалдах хуудсыг тойруулан, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга болон хэлтсийн дарга нараар хянуулан зөвшөөрөл авч хэвшсэн. “Хууль зүйн салбарын Нээлттэй бодлого”-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд 11 сарын байдлаар 283 захирамжийг аймгийн www.dundgovi.gov.mn вэб сайтын эрх зүйн актууд цэсний Засаг даргын захирамжууд хэсэгт байршуулан иргэд, олон нийтэд сурталчлан таниулсан.



Засаг Даргын захирамж

№	Дугаар	Төрөл	Огноо
1	А/365	Буюуцалгийн авчиргааныг зохион байгуулах тухай	2017-10-23
2	А/366	Гэрээ байгуулах тухай	2017-10-26
3	А/367	Газар зориулах зориулалт өөрчлөх тухай	2017-10-19
4	А/368	Газар зориулах эрхийг шилжүүлэх тухай	2017-10-19
5	А/369	Өмч нь гэр бүлийн харагчид дундаа хантраа өмчлөх гэрээ гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх тухай	2017-10-19
6	А/364	Монгол Улсын иргэнд газар ижилүүлэх тухай	2017-10-18
7	А/363	Валкелетийн газар эвчлэх арга тухай	2017-10-18

Аймгийн Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран “Агаарын чанарын бүсийг тогтоох журам”-ыг Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн дагуу боловсруулан, журмыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайдтай хамтран батлан гаргаж, хянуулахаар хүргүүлээд байна.

Сумын Засаг даргын шийдвэр хууль тогтоомжид нийцэж буйг хянахад хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар авсан арга хэмжээ

Тус онд сумдын Засаг дарга нарын болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагийн дарга нараас батлан гаргасан эрх зүйн актуудыг хуваарийн дагуу хянах ажлыг зохион байгууллаа.

Тус хугацаанд сумдын Засаг дарга нараас 2017 оны эхний 3 улиралд батлан гаргасан нийт 1162 эрх зүйн актын хууль зүйн үндэслэлийг хянаж үүнээс хуулийн зүйл заалтыг буруу үндэслэсэн 46 зөрчлийг арилгуулах, эрх



олгогдоогүй шийдвэр гарсан 42 захирамжийг хүчингүй болгох талаар зөвлөмж, мөн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нийт 10 агентлагийн даргын батлан гаргасан 486 тушаалыг хуваарийн дагуу хянаж, гарсан зөрчлийг арилгуулахаар зөвлөмжүүдийг хүргүүлж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллалаа. Тушаалаа хянуулаагүй хэлтэс, агентлагуудад анхааруулах санамж бичиг хүргүүлсэн.

Нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсан эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын чанар, үр дүн, шинээр боловсруулж буй хууль тогтоомжийн төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, санал авсан талаар

Тус онд сум, байгууллага, иргэдийн санал хүсэлтээр эрх зүйн албан ба албан бус сургалтыг 32, сурталчилгааг 5, хэлэлцүүлэг 4 удаа тус тус зохион байгуулж 3435 гаруй иргэнийг хамруулж, зөвлөгөө, лавлагаа, баримт бичиг боловсруулах чиглэлээр 32 иргэндэрх зүйн туслалцаа үйлчилгээг үзүүллээ. Иргэд ихэвчлэн хөдөлмөрийн болон гэр бүлийн харилцаа, иргэн байгууллага хоорондын маргаан, хохирол нөхөн төлүүлэх, хулгайд эд зүйлсээ алдсан, өмгөөлөгч авах, тэтгэвэр тэтгэмж тогтоолгох, ашиг сонирхлын зөрчил, хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах, зөрчлийн тухай, хүний эрхийн тухай хууль тогтоомжуудаар ханддаг тул тус сэдвүүдээр гарын авлага бэлтгэх, сурталчлан таниулах ажлыг илүүтэй зохион байгуулж, төрийн албан хаагчдын болон иргэдийн эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлсэн үр дүнтэй жил байлаа. Үүнд:

➤ “Иргэний эрх зүйн боловсрол” аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Эрх зүйн хөтөч” орон тооны бус багийн ахлагч/сумдын ЗДТГ-ын дарга/ нарын үйл ажиллагааг эрчимжүүлж чадавхжуулах чиглэлээр эрх зүйн сургалтыг жил бүр зохион байгуулж хэвшүүллээ.

➤ Тус оны “Эрх зүйн хөтөч” багийн ахлагч буюу сумын

ЗДТГ-ын дарга нарыг чадавхжуулах сургалтыг 2017 оны 05 дугаар сарын бүлийн хүчирхийлэлтэй хууль, хэрэгжүүлэхэд Эрх зүйн актыг анхаарах асуудал,



23-ны өдөр Гэр тэмцэх тухай анхаарах асуудал, боловсруулахад холбогдох дүрэм

журам, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах ЭБАТ-ны үйл ажиллагаа, тайлан мэдээ ирүүлэх, гаргахад анхаарах асуудал,

Цагдаагийн албаны тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль тогтоомж, Нотариатын үйл ажиллагааг эрхлэн явуулахад анхаарах асуудал, холбогдох дүрэм журам, Улсын бүртгэлийн байгууллагын хамтын ажиллагаа, Эрх зүйн сургалт, сурталчилгаа зохион байгуулах арга зүй, хамтын ажиллагаа, Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын хяналт шинжилгээ хийх аргачлал сэдвүүдээр, дараагийн өдөр буюу 05 дугаар сарын 24-ний өдөр Хууль зүй дотоод хэргийн яамтай хамтран Захиргааны ерөнхий хуулийн агуулга, үзэл баримтлал, Захиргааны шийдвэр гаргах ажиллагаа, Захиргааны хэм хэмжээний акт, Захиргааны бусад үйл ажиллагаа, Захиргааны актад гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх зэрэг сэдвүүдээр тус тус зохион байгууллаа.

Сургалтын явцад Дэлгэрхангай, Баянжаргалан сумдын “Эрх зүйн хөтөч” багийн арга туршлага, мэдээллийг сонсож, харилцан ярилцаж, асуулт хариулт явагдлаа.

Аймгийн Засаг даргын тамгын газрын удирдлагуудаас сургалтын төгсгөлд цаг үеийн болоод хамтран ажиллах талаар санал солилцож, сургалтын үйл ажиллагааг дүгнэлээ.

➤ Эрх зүйн хөтөч багийн эрчимжүүлэх зорилгоор тамгын газрын албан хаагчдас 2017 онд судлах, сурталчлан таниулах хууль улирал бүр 6 хууль байгуулахаар боловсруулан хамтран ажиллаж 1390 материал, арга зүйгээр



үйл ажиллагааг сумын Засаг даргын тушаалтан, албан иргэд олон нийтэд тогтоомжийн жагсаалтыг тогтоомжоор зохион хүргүүлж, хяналт тавин гаруй гарын авлага ханган ажиллалаа.

➤ Аймгийн ИТХ-ын дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх /ГХУС/ ажлыг зохицуулах салбар Зөвлөлийн даргын баталсан удирдамжийн дагуу ГХУСАЗСЗөвлөлийн гишүүдтэй хамтран Татварын хэлтсийн улсын байцаагч, нийтийн албан тушаалтнуудад, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн Авлигын эсрэг, Ашиг тухай хууль сурталчлан таниулж, албан хаагчдын дунд



албан хаагчдад ГХУС, сонирхлын зөрчлийн тогтоомжуудыг сургалтын төгсгөлд заагдсан сэдвүүдээр

асуулт, хариулт бүхий танин мэдэхүйн уралдаан тэмцээн зохион байгуулж, шалгарсан баг, идэвхтэй оролцсон нийтийн албан тушаалтнуудыг ГХУСАЗСЗ-өөс шагнаж урамшууллаа.

➤ Аймаг, сумын ЗДТГ-ын дарга, сум, багийн Засаг дарга, байгууллагын дарга, эрхлэгч, сумын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нар нийт 199 албан хаагчдад ЗДҮАХ, Эдийн засаг нийгмийг

хөгжүүлэх үндсэн дарга нартай зүйн хүрээний яаж хэрэгжүүлэх, эрх бэлтгэх, түгээх зөвлөмжийн талаар Б.Түвшинбаяр,



чиглэл, Засаг байгуулсан хууль асуудлыг хэрхэн зүйн мэдээлэл аргачилсан хэлтсийн дарга ХАСУМ, ХАСХОМ-

ийг гаргах эрх зүйн зохицуулалт, анхаарах асуудлуудаар ахлах мэргэжилтэн С.Цэнгэлмаа нар эрх зүйн сургалт зохион байгууллаа.

➤ “Иргэний эрх зүйн боловсрол” аймгийн II шатны үйл ажиллагааг хэрэгжүүлэх Иргэдэд хууль тогтоомж сурталчлах радио нэвтрүүлгийн байнгын удирдамжийг Засаг даргаар батлуулан Засаг даргын асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, хууль байгууллагуудыг сар бүрийн 01-30-ны сард 1 удаа Аюулаас сэрэмжлүүлэх FM107.5-аар өдөр бүр иргэд, олон нийт,



хөтөлбөрийн хүрээнд “Хуулийн цаг” аймгийн эрхлэх хяналтын өдрүүдэд цогцолбор малчдад

хууль тогтоомжийг сурталчлан таниуллаа. Мөн Захиргааны ерөнхий хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль зэргийн иргэдэд хамааралтай зүйл заалтаар гарын авлага бэлтгэн 9 суманд нийт 380 ширхэгийг хэвлэн тараахад 250,000 төгрөг зарцуулсан.

➤ Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Иргэдээ сонсоё” төрийн үйлчилгээ нэгдсэн өдөрлөг арга хэмжээг Гурвансайхан, Өндөршил сумдад 2017 оны 03 дугаар сарын 27-30, Луус, Хулд сумдад 2017 оны 11 дүгээр сарын 02-03-ны өдрүүдэд аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын дарга, аймгийн ЗДТГ-ын 6 хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 70 гаруй албан хаагчид төрийн захиргааны удирдлага, эрүүл мэнд, боловсрол, спорт, соёл урлаг, хууль эрх зүй, өмгөөлөл, санхүү татвар, статистик, улсын бүртгэл, явуулын музей, номын сан зэрэг төрийн бүх төрлийн үйлчилгээг хөдөөгийн

малчид, иргэдэд нэг цэгээс хүргэж үйлчиллээ. Тус сумдад Хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч, цагдаагийн газрын Олон нийттэй харилцах ажилтан, Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүд хамтран иргэдтэй уулзаж хууль, эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгч, 12 төрлийн хуулиар хялбаршуулсан нугалбар бүхий 320 ширхэг гарын авлагыг иргэдэд түгээж сурталчилсан.

➤ Татварын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Дэлгэрцогт, Гурвансайхан, Өндөршил сумын ЗДТГ,

Сайнцагаан сумын II цэцэрлэгийн хамт гаруй иргэдэд эрх сургалтуудыг сонирхлын тухай хууль таниулах нь”,



олон, нийт 230 зүйн албан бус “Авлига, ашиг зөрчлийн тогтоомжийг “ХАСХОМ”,

“Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг”, “Мэдэгдэл, тайлбар гаргах тухай”, “Эвлэрүүлэн зуучлалын тухай”, “Захиргааны ерөнхий хууль”, “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх төрийн бодлого, удирдах ажилтны үүрэг, оролцоо” “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай зэрэг хууль тогтоомжоор зохион байгууллаа.

➤ Тус хэлтсээс “Хууль зүйн мэдээлэл” төслийг боловсруулан аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 3,000,000 төгрөгөөр батлуулж шинээр батлагдан хэрэгжиж буй Зөрчлийн, Зөрчил шалган шийдвэрлэх, Эрүүгийн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Прокурорын, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, Эвлэрүүлэн зуучлалын тухай, Хүний эрхтэй холбоотой хууль тогтоомжуудыг сурталчлах зорилготой баруун, зүүн сумдаар 2 хэсэг ажиллаж “Иргэдэд хууль тогтоомж сурталчлах өдөрлөг”-ийг аймгийн 14 сумын 1043 иргэд, төрийн албан хаагчдыг оролцуулан зохион байгуулж, үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөөг 35 иргэнд үзүүллээ.

➤ Дээрх хуулиудаар аймгийн төвийн төрийн албан хаагчид болон хууль хяналтын албан хаагчдад Монголын хуульчдын холбоотой хамтран нэг өдрийн эрх зүйн сургалтыг тус тус зохион байгуулж, мэдлэг боловсролоо дээшлүүлж, ойлголтын зөрүүтэй асуудлуудыг нэг мөр ойлгох асуулт, харилт явагдлаа.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохионбайгуулсан ажлын үр дүн

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хуралдаанаар өнгөрсөн оны ажлын тайлан болон 2017 онд хэрэгжүүлэх 4 бүлгийн 24 асуудал бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн баталж, сум, байгууллагуудад хүргүүлэн, төлөвлөгөөний явцад хяналт тавин эрчимжүүлж, зохион байгуулж буй ажлын мэдээг аймгийн www.dundgovi.gov.mn, ГХУСАЗС-ийн www.cccp.mn сайтуудад тус тус байршуулан сурталчилж байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ерөнхий арга хэмжээ 5, тусгай арга хэмжээг 14-ийг зохион байгуулж биелэлт үр дүнг нь тооцоод байна.

Хүчирхийллийн эсрэг Үндэсний төвийн ус аймаг дахь салбар Говийн бүсийн мэдээлэл үйлчилгээний төвийн хамгаалах байрны өмчлөлийн асуудлыг шийдвэрлэж, үйл ажиллагааг сэргээх, тус байрны урсгал засвар, үйлчилгээг хийх зардлыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 2,5 сая төгрөгийг шийдвэрлэн засварын ажлыг хийв. Цаашид тус байрны хэвийн ажиллагаа, тасралтгүй үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлж аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 1 хүний орон тоог шийдвэрлэн ажиллуулж байна.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийг зөвлөлийн гишүүдэд хувиарлан хамтран тодорхой төрлийн ажил арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Үүнд:

Сум, байгууллагуудын дунд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, архидан согтуурахтай тэмцэх, аливаа хүчирхийлэл, танхайрах, хулгайн болон зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийн оролцоо, идэвх санаачлагыг нэмэгдүүлэх, тэдний хууль эрх үйн мэдлэгийг дээшлүүлэх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж /цагдаа-олон нийт/-ийн хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр “ГЭМТ ХЭРЭГ ЗӨРЧИЛГҮЙ-АЮУЛГҮЙ АМАР ТАЙВАН ОРЧИН” аяны цомыг аяны удирдамж, зааварын хамт 2017.04.24-өөс эхлүүлэн суманд 14 хоног, байгууллагад 7 хоногийн хугацаатай аялуулан зохион байгуулж байна. Тус аяны цом 10 сум, 25 байгууллага, аж ахуйн нэгжээр аялж тухайн сум, байгууллагууд тодорхой ажлуудыг өрнүүлж байна. Аяны явц үр дүнтэй зарим сумдад газар дээр нь очиж танилцан, сумын ГХУСАЗС-ийн гишүүдэд аяныг үр дүнтэй зохион байгуулах талаар заавар зөвлөгөө өглөө. Тус аяныг 2017 оны 12



дугаар сарын 25-нд дүгнэж, Гэмт хэрэг зөрчилгүй сум,баг, байгууллага, хамт олныг шалгаруулж, үр дүнг тооцно.

“Архигүй Дундговь” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 05 дугаар сард 100 гаруй иргэд, төрийн албан хаагчдад архидалтын хор хөнөөл түүнээс



урьдчилан сэргийлэх чиглэлээр Монголын эрэгтэйчүүдийн нийгэмлэгийн тэргүүн, МУ-ын Соёлын гавьяат зүтгэлтэн Ж.Цогсугираар “Оюун тархины гэрэл, гэгээ” сэдэвт лекц уншууллаа. Тус арга хэмжээний үеэр аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ хамтын ажиллагааны “Санамж бичиг”-т байгуулж,

сумдын удирдлагуудад хүргүүлж хамтран ажиллах талаар чиглэл өгсөн. Санамж бичгийн хүрээнд зарим сум идэвх, санаачлага гарган хэрэгжүүлж эхлээд байна.

Тухайлбал: Адаацаг сум тус ТББ-ын лектор А.Батсайхантай хамтран архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр “Монгол хүний үнэ цэнэ, үнэлэмж” сэдэвт лекц иргэдэд уншуулсан. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, стандартын шаардлага хангаагүй согтууруулах ундаа



худалдаалагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Архи амьдралын дайсан” арга хэмжээг нэг сарын хугацаатай зохион байгуулсан

Арга хэмжээний үр дүнд удаа дараа Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиар арга хэмжээ авагдсан, байгууллагынхаа аюулгүй байдлыг бүрэн хангаж ажилладаггүй аж ахуй нэгжүүдийн тусгай зөвшөөрлийг цуцлуулахаар холбогдох байгууллагад хүсэлт тавьж 12 аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулсан. Одоо аймгийн хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчилдэг



борлуулдаг 113 цэгт хяналт тавин ажиллаж байна. Архины хамааралтай зорилтот бүлгийн хүмүүсийн амьдралд хандах хандлагыг эерэгээр өөрчилж, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт хөтөлбөрт хамруулж, “Говийн хийморь” АА бүлгийн тэргүүн туршлагыг сурталчлах зорилгоор 2017.01.30-ны өдөр

“Өөрчлөлтийг өөрөөсөө” арга хэмжээг Сайнцагаан сумын ЗДТГ, ГХУСАЗСЗ, ХХҮГ,

"Говийн хийморь" АА бүлэгтэй хамтран зохион байгуулсан. 2017.03.18-ны өдөр Дундговь аймгийн Өлзийт сумын 6 дугаар багийн иргэн Ц.Ганхуягийн санаачлан зохион байгуулсан "Архигүй амьдрал аз жаргалын эхлэл" арга хэмжээнд оролцож, архины хор уршиг сэдвээр сургалт явуулж, 6 алба хаагчийн бүрэлдэхүүний бие хамгаалах үзүүлэх тоглолтыг иргэд, олон нийтэд үзүүлсэн. Аймгийн "Говийн хийморь" АА бүлгийн 4 жилийн ойн арга хэмжээг тус бүлэгтэй хамтран 2016 оны 04-р сарын 22-ны өдөр хамтран зохион байгуулсан. АА бүлгийн 4 жилийн ойн арга хэмжээнд Улаанбаатар хотын болон бусад орон нутгийн АА бүлгийн нийт 200 гаруй иргэд хүрэлцэн ирж, бүх нийтийн уулзалт, ярилцлага хийгдсэн. АА бүлгүүдийн уулзалт ярилцлаганд архины хамааралтай 30 иргэнийг хамруулж, АА бүлгийн туршлагыг нэвтрүүлж ажилласан. Үүний үр дүнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 34 хувиар буураад байна.


Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны талаарх бодлого, шийдвэрийг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, архивын тасгаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, архивын сан хөмрөгийн хадгалалт, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг сайжруулах чиглэлээр хийсэн ажлын талаар

Архивын Ерөнхий газрын даргын 2009 оны 69 дүгээр тушаалаар батлагдсан "Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналт шалгалтын үйл ажиллагааны заавар"-ын дагуу 2017 онд хяналт шалгалт явуулах төлөвлөгөө графикийн дагуу Говь-Угтаал, Цагаандэлгэр, Баянжаргал, Өндөршил, Өлзийт сумын ЗДТГазар, аймгийн ЗДТГазар, ЭМГ, УЦУОШГ, Онцгой байдлын газар, аймгийн Аудитын газар зэрэг сум, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулж, аймгийн ЗДТГазар, Аудитын газар зэрэг байгууллагад албан шаардлага хүргүүлж илэрсэн зөрчил дутагдлуудыг газар дээр нь арилгуулах арга хэмжээ авч, бусад байгууллагад илтгэх хуудсаар зөвлөмж бичиж мэргэжил арга зүйн зөвлөгөөгч ажиллалаа.

МУ-ын Засгийн газрын 2000 оны 86 дугаар тогтоолын дагуу Архивын Ерөнхий газрын дэргэдэх мэргэжил олгох, дээшлүүлэх, давтан сургах сургалтын төвд суралцуулах тухай захиалгыг сум, байгууллагуудаас авч Архивын Ерөнхий газарт хүргүүлсний дагуу 2017 онд анхан шатны сургалтанд 5, давтан болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд 12 архив, бичиг хэргийн эрхлэгч нарыг хамруулан сургалаа.

Үндэсний стандарт хэмжил зүйн төвийн Зөвлөлийн 2011 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан баримт бичгийн стандартын дагуу боловсруулж гаргасан байдалд Хууль, эрх зүйн хэлтсийн хуулийн зөвлөлтэй хамтран сумдын Засаг даргын захирамж, сум, байгууллагын даргын шийдвэрийг баримт бичгийн

стандартын дагуу боловсруулж гаргасан эсэхийг хянан үзэж нийт 26 сум, байгууллагын захирамж, тушаалын зөрчилд зөвлөмж бичиж хүргүүлэн зөрчлийг



арилгууллаа.

Багийн Засаг дарга, аймгийн Эрүүл мэндийн газар, Татварын хэлтэс, УЦУОШАлбаны ажилтан албан хаагчид, сумдын УЦУОША хариуцсан ажилтнууд болон сумдын эрүүл мэндийн төвийн эрхлэгч, дүн бүртгэгч, Татварын

байцаагч нарт нийт 200 гаруй албан хаагчдад архив, албан хэрэг хөтлөлтийн талаар сургалт явууллаа.

МУ-ын Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийн 4 дэх үе шатны зорилтыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор 2017 онд цахим санд оруулах хөмрөг үүсгэгч байгууллагын жагсаалт, төлөвлөгөөг гарган ажилласны үндсэн дээр 2017 онд **33 хөмрөгийн**: 573 ХН буюу 42983 хуудас баримт скайнардан засварлаж, 553ХН буюу 40127 хуудас баримтын заалтыг тодорхойлон бичиж, 582 ХН буюу 40583 хуудас баримтанд цахим холболтыг тус тус хийж 2017 оны байдлаар хөмрөг үүсгэгч байгууллагын 94,2 хувь нь цахим санд ороод байна.



Үндэсний архивын Газрын даргын 2016 оны А/65 тоот тушаалаар батлагдсан “Төрийн архивын баримт ашиглалтын нийтлэг журам”-ыг мөрдөн ажиллаж архивын баримтыг ашиглуулах зорилгоор иргэд, байгууллагын нийгэм эрх зүйн шинж чанартай лавлагаа олгох ажлыг хийж гүйцэтгэсний дүнд 2017 онд нийт 970 иргэний хүсэлтийг хүлээн авч **857** хүнд хувь хуулбар, хэсэгчилсэн хуулбар олгож

мэдээлэл

2.485.000

төвлөрүүлсэн.

Тус онд

“Нээлттэй

хаалганы



680 гаруй хадгаламжийн нэгжийг лавлагаанд ашиглуулж нийт мянган төгрөгийн орлого



өдөрлөг"-ийг аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэстэй хамтран зохион байгуулж Төрийн архивын танилцуулга болон архивын сан хөмрөгөөс 1996-2015 оны аймаг орон нутгийн түүхэн үйл явдлыг харуулсан гэрэл зургийн альбомчилсон 7 ботиудаар үзэсгэлэн гаргаж нийтийн хүртээл болгов.

Төрийн архивын баримтын хадгалалт, хамгаалалтын тохиромжтой нөхцлийг бүрдүүлэх, аюулгүй байдлын баталгааг бий болгох асуудлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулснаар АЕГ-аас 20 гаруй сая төгрөгний 40 ширхэг нягтруулсан шүүгээ, 100 баримт зөөвөрлөх хайрцаг, 70 ширхэг барилгын зургийн баримтын хайрцаг зэргийг үнэ төлбөргүй өгч суурилуулаад байна.



Хууль зүй, дотоод хэргийн яамнаас өгсөн үүрэг даалгавар /сайдын албан даалгавар/, хууль сахиулах байгууллагуудын харилцан ажиллагааг уялдуулан зохицуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хамтын ажиллагааны үр дүн

Нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын талаар аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар Цагдаагийн газрын даргын сонсгол, мэдээллийг хэлэлцэн сонсож, статистик тоо, мэдээнд сар тутам дүгнэлт өгч нөхцөл байдал болон Цагдаагийн байгууллагаас гаргасан саналыг үндэслэн зохион байгуулалтын болоод бусад дэмжлэг туслалцаа үзүүлэн ажиллалаа.

Сумдын цагдаа, хэсгийн төлөөлөгч нарыг унаажуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг сумдын Засаг дарга нартай байгуулсан гэрээнд тусган үе шаттай шийдвэрлэж дэмжлэг үзүүлэн хамтран ажиллалаа.



2017 онд аймгийн Цагдаагийн газрын ЗЦТ-т 4 ширхэг бэлэн бусын торгуулийн багажаар хангах асуудлыг 10,0 сая төгрөгөөр, хөдөөгийн 5 сумын хэсгийн төлөөлөгчийг унаажуулах /мотоцикль/ 10,0 сая төгрөгний хөрөнгийн асуудлыг ОНХС-ийн хөрөнгөөр тус тус шийдвэрлэж худалдан авалт хийгдэж үйл ажиллагаандаа хэвийн ашиглаж байна. Сайнцагаан сумын ИТХ-ын 2017.04.03-ны өдрийн 01 тоот тогтоолоор Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс нийт 4,500,000 төгрөгний өртөг бүхий Dron камер 1 ш, бэлэн бусторгуулийн тоног

төхөөрөмж 1 ширхэг, Адаацаг сум мотоцикл, Өлзийт сум Dron камер, Луус, Хулд, Өлзийт сумд бэлэн бус торгуулийн төхөөрөмжийг Цагдаагийн хэсэгтээ тус тус олгосон.

Хууль зүйн салбарын шинэчлэлийн хүрээнд хууль хяналтын байгууллагууд хамтран “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 06 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулж, уг үйл ажиллагаанд аймгийн Шүүх, Прокурор, Цагдаагийн газар, ХЭҮК-ын аймаг дахь ахлах Хуульч эмэгтэйчүүдийн холбооны ШША, Хууль зүйн туслалцааны Архивын тасаг, Нотариатын оролцлоо. Тус арга хэмжээг талбайд зохион байгуулж, энэ нийтэд байгууллага бүр үйл сурталчлах, мэдээ мэдээлэл, хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө, туслалцааг үзүүлж, санал асуулга авах, өргөдөл, гомдлыг газар дээр нь шийдвэрлэхийн зэрэгцээ иргэдийн дунд “АХА” уралдаант тэмцээн, “Бие хамгаалах” үзүүлэх тоглолт тус тус зохион байгууллаа.



Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг дээшлүүлэх үүднээс “Зам тээврийн гэмт хэрэг, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, цаашид анхаарах асуудал” сэдвийн хүрээнд мэргэжлийн байгууллагуудын дунд хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Хэлэлцүүлэгт Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, аймгийн Авто тээврийн төв, Сайнцагаансумын Хот тохижилтын газар, Мэргэжлийн хяналтын газар, “Мандалговь А0102” төлбөр авах цэгийн ажилтан нар оролцож санал бодлоо солилцлоо. Тус хэлэлцүүлгээр ГБХЗХГазар “Хүүхэд багачуудыг замын хөдөлгөөнд оролцуулахад анхаарах асуудал”, Эрүүл мэндийн газар “Зам тээврийн осол гэмтлийн талаарх мэдээлэл”, Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдал, анхаарах асуудал”, аймгийн Авто тээврийн төв “Авто замын засвар үйлчилгээ, цаашид анхаарах асуудал” сэдвүүдээр тус тус мэдээлэл хийж, оролцогчид асуулт асууж, тулгамдсан асуудлаар саналаа илэрхийлж цаашдын хамтын ажиллагаа, анхаарах асуудлаар нэгдсэн ойлголтод хүрч зөвлөмж гаргалаа. Мөн бага насны хүүхдийг зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх үүднээс “School police”-г явуулж, эцэг эхчүүдийг энэ үйл ажиллагаанд татан оролцуулж сургууль, цэцэрлэгийн гадна талд эргүүлийн үүрэг байнга гүйцэтгэж байна.

Мөн Онцгой байдлын хэлтсийн дэргэдэх Аюулаас сэрэмжлүүлэх цогцолборын радио долгионы 107,5-аар сар бүрийн тогтсон өдрүүдэд хууль, эрх зүйн хэлтсийн харьяаны хэлтэс, албадууд хууль тогтоомж болон өөрийн байгууллагын цаг үеийн ажилтай холбогдсон мэдээлэл сурталчилгааг тогтмол зохион байгуулж байна.

Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээллийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 4 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, санал бодлыг сонсож, үр дүнг эргэж мэдээллэх үүрэг даалгаврыг өгч ажиллалаа.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний биелэлтийг хангахад зохион байгуулалтын арга хэмжээ авах, гэрээний биелэлтийн тайлан мэдээ, дараа оны гэрээнд тусгах саналыг нэгтгэх талаар

Хууль зүй, дотоод хэргийн сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд Хяналт шинжилгээ, дотоод аудитын хэлтэстэй хамтран явцын үнэлгээ хийж цаашид гэрээний хэрэгжилтийг үр дүнтэй эрчимжүүлэх талаар зөвлөмж өгч дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Тус онд аймгийн ОНХС-ийн хөтөлбөр арга хэмжээний зардлаас “Иргэний эрх зүйн боловсрол” аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 3,0 сая төгрөгийн өртөг бүхий зардлаар хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд сурталчлах чиглэлээр “Хууль зүйн мэдээлэл” төслийг батлуулж 10, 11 дүгээр сард хөдөөгийн 13 суманд “Хууль тогтоомж сурталчлах өдөрлөг” арга хэмжээг хууль хяналтын байгууллагын албан хаагч нартай хамтран зохион байгуулах үеэр 2017 оны 7 дугаар сарын 1-нээс мөрдөн хэрэгжиж буй Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Прокурорын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, Эвлэрүүлэн зуучлалын тухайзэрэг хууль тогтоомжуудыг 1043 иргэд, албан хаагчдад сурталчилан таниулж, дээрх бүх сэдвүүдээр гарын авлага материал бэлтгэн тараасан. Мөн хууль хяналтын байгууллагуудын албан хаагчдад Монголын хуульчдын холбооноос бэлтгэгдсэн сургагч багш нарыг урьж нэг өдрийн эрх зүйн сургалтыг зохион байгуулж, асуулт хариулт явагдсан.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид шаардлагатай үйлчилгээг үзүүлэх зардал, шүүхээр баривчлагдсан иргэдэд зан үйлийн сургалтанд хамгадах, хүчирхийлэгч нарт зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг “Оюуны гэгээ” ТББ-тай хамтран 5 удаагийн сургалтыг зохион байгуулан 20 хүнийг хамруулсан. Тус үйл ажиллагаанд 240,0 мянган төгрөгийг аймгийн Засаг дарга хариуцан санхүүжүүлсэн.



Аймгийн төвд Гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг гудамж, зам талбай, олон нийтийн газар, эмзэг цэгүүдийг 62 телекамераар хянаж байна. Аймгийн ИТХ-ын 2016 оны 31 тоот тогтоолын биелэлтийг хангах, аж ахуйн нэгж байгууллагуудын аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, хамтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор “Камер, дохиолол, гэрэлтүүлэг” ерөнхий арга хэмжээг зохион байгууллаа. Уг арга хэмжээний үр дүн аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг 92 байгууллага, аж ахуй нэгж тодорхой хэмжээнд камержиж, гадна орчноо гэрэлтүүлэгтэй болгож, дохиоллын системд холбогдож эхлээд байна.

Тус онд аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасагт 4 ширхэг бэлэн бус торгуулийн багажаар хангах асуудлыг 10,0 сая төгрөгөөр, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Өндөршил, Гурвансайхан, Баянжаргалан зэрэг 5 сумын хэсгийн төлөөлөгчийг унаажуулах /мотоцикль/ 10,0 сая төгрөгний хөрөнгийн асуудлыг ОНХС-ийн хөрөнгөөр шийдвэрлэсэн.

Архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах хүрээнд 2.148.820

мянган төгрөгөөр хөгжлийн сангийн шийдвэрлэж, нягтруулсан шүүгээ зөөвөрлөх хайрцаг хамгаалалтын ширхэгийг Архивын хөнгөлөлттэй




орон нутгийн хөрөнгөөс архивын баримтын 40 ш, баримт 100 ш, баримтын хайрцаг 70 ерөнхий газраас нөхцөлөөр гэрээ

байгуулан авч, 9 хөмрөг үүсгэгч байгууллагуудын 1000 гаруй хадгаламжийн нэгж баримтыг байрлууллаа.

Хүний эрхийн талаархи хууль тогтоомж, иргэд, байгууллагад сурталчлах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан ажлын үр дүнгийн талаар

Хүний төлөөлөгч, Хууль өмгөөлөгч нар ажиллаж үйл хэвийн явагдаж ажилтны нөхцлийг ханган аймгийн Засаг даргын Тамгын газарт ажлын өрөөгөөр хангасан.



эрхийн үндэсний комиссын аймаг дахь зүйн туслалцааны төвийн улсын орон тоогоор ажиллагаа нь байна. Тус хоёр ажиллах



Аймгийн хууль хяналтын байгууллагуудтай болон “Оюуны гэгээ”, “Элгэмсэг дотно Дундговь холбоо” төрийн бус байгууллагатай хамтран 2017 оны 10 дугаар сарын 23-наас 11 дүгээр сарын 03-ны өдрүүдэд аймгийн 15 суманд “Иргэдэд хууль тогтоомж сурталчлах өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулсан.

2017 онд хууль зүйн зөвлөгөөг 340, өмгөөллийн үйлчилгээг 51, нийт 391 иргэнд хууль зүйн болон өмгөөллийн туслалцаа үзүүллээ. Үүнээс шүүхээр 45 холбогдогчтой 41 хэрэг, шүүхийн өмнөх шатанд 8 холбогдогчтой 7 хэргийг тус тус шийдвэрлүүлсэн.

Хүний эрхийн үндэсний комиссын аймаг дахь төлөөлөгч, Хууль зүйн туслалцааны өмгөөлөгч нартай хамтран тус онд Гурвансайхан, Өндөршил, Сайнцагаан сумдад “Иргэдээ сонсьё”, “Хуулийн байгууллагуудын нээлттэй хаалга”-ны нэгдсэн арга хэмжээг зохион байгуулан 70 гаруй иргэдтэй уулзаж, 12 иргэнд хууль, эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө үйлчилгээ үзүүлсэн.



Хүний эрхийн Олон улсын өдрийг тохиолдуулан Хүний эрхийн үндэсний комиссын аймаг дахь төлөөлөгч болон хууль сахиулах байгууллагуудтай хамтран иргэд, байгууллагуудад хүний эрхийг хангах, хамгаалах, хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгч, гарын авлага, материал бэлтгэн

тарааж ажилласан ба аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудад “Бизнес ба хүний эрх”, “Хөдөлмөрлөх эрх” сэдвээр эрх зүйн сургалтыг зохион байгууллаа.

Мөн Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газартай хамтран “Гэр бүлийн хүний эрхийн зөрчил” сэдвээр “Сайнцагаан-Сүүн Сайнцагаан” орон нутгийн сонинд нийтлэл гаргаж иргэдэд сурталчиллаа.

ТАЙЛАН БИЧСЭН: ХЭЗХ-ИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН С.ЦЭНГЭЛМАА

ТАЙЛАН ХЯНАСАН:
ХЭЗХ-ИЙН ДАРГА Б.ТҮВШИНБАЯР

Дундговь аймаг

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СИСТЕМЧЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ,
ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ТУСЛАЛЦААНЫ ТАЛААРХ 2017 ОНЫ ЖИЛИЙН
АЖЛЫН МЭДЭЭ

Д/д	Ажлынчиглэл	Үзүүлэлт		Сум,	Хууль, эрх зүйн хэлтэс	Бүгд
1	Хууль тогтоомжийн системчлэл мэдээлэл	Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санд байгаа эрх зүйн актын тоо		“Төрийн мэдээлэл” сэтгүүл болон www.legalinfo.mn сайт ашигладаг	3925	3925
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санг шинээр баяжуулсан эрх зүйнактын тоо			364	364
		Системчлэл хийсэн хууль тогтоомж		-	-	-
		Өөрчлөлт хөдөлгөөн хийсэн зүйл заалтын тоо		-	425	425
		Эрхзүйн мэдээллийн нэгдсэн системээс лавлагаа мэдээлэл өгсөн	Иргэд	25	33	58
			Байгууллага	10	25	35
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн гар сангаас лавлагаа, мэдээлэл өгсөн	Иргэд	43	44	87
Байгууллага	8		8	16		
2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянах	Хянаж санал өгсөн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамж		1162	321	1483
		Үүнээс захиргааны хэм хэмжээ тогтоосон захирамж	Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж бүртгүүлсэн	-	-	-
			Хууль зүй, дотоод хэргийн яамнаас дүгнэлт гаргаж буцаасан	-	-	-
3	Эрх зүйн сургалт, сурталчилгаа	Зохион байгуулсан эрх зүйн сургалт, хэлэлцүүлэг		30	36	66
		Үүнээс сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан хүний тоо		5106	3435	8541
		Зохион байгуулсан эрх зүйн сурталчилгаа		35	5	40
		Боловсруулсан гарын авлага, сургалт, сурталчилгааны материал		1335	2140	3475
		ФМ, Радио, телевизийн нэвтрүүлэг		5	10	25
		Сонин хэвлэлээр сурталчилсан		5	1	6
		Бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан		-	8	8

МЭДЭЭГ ГАРГАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН С.ЦЭНГЭЛМАА
МЭДЭЭГ ХЯНАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА Б.ТҮВШИНБАЯР

